



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/73

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хэнтий аймгийн Дадал суман дахь “Дэлүүнболдог” нисэх буудалд байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга: Л.Ганбат

Худалдан авах ажиллагааны тасгийн дарга

Нарийн бичгийн

дарга: Ч.Ганзориг

Худалдан авах ажиллагааны тасгийн
мэргэжилтэн

Гишүүд:

Г.Наранчимэг

Нисэх буудлуудын үйлчилгээний газрын
мэргэжилтэн

Б.Бат-Эрдэнэ

Иргэний нисэхийн залуучуудын холбооны гишүүн

М.Оргил

“Сэтгэл зүй, судалгаа мэдээллийн төв” Төрийн
бус байгууллагын судлаач

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Л.Ганбат)-нд үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Хуулийн хэлтэст хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ч.Ганзориг)-д даалгасугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ